



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/493

Булган сум

**Хуулийн хэрэгжилтийг
хангуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дахь заалтыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгууль Хангал суманд зохион байгуулахтай холбогдуулан тус сумын нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг 2023 оны 06 сарын 17-ны өдрөөс 2023 оны 06 сарын 19-ний өдрийг дуустал түр хориглосугай.

2. Санал авах өдөр буюу 2023 оны 06 сарын 18-ны өдөр Хангал суманд гадаа болон битүү талбайд худалдаа, үйлчилгээ явуулах, соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олон нийтийг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулахгүй байхыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Л.Ганбаатар), Хангал сумын Засаг дарга (М.Төмөрбат) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6320010492